# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр Дугаар А/695 Булган сум

**Түгээмэл тархацтай ашигт малтмал
түр ашиглах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Засгийн Газрын 2024 оны "Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай" 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа "Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто зам"-ын барилга угсралтын ажилд шаардагдах шороон орд, чулууны карьерын байршлын координатыг хавсралтаар баталсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд нэн даруй мэдээлэх, авто замын барилгын ажил дууссаны дараа ашигласан талбайг холбогдох стандартын дагуу орон нутагт нөхөн сэргээж, хүлээлгэн өгөхийг "Идэр ширэгү" ХХК (Т.Түвшин)-д даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмал түр ашиглуулах гэрээг төслийн ажлыг дуустал хугацаанд байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч ажиллахыг Гурванбулаг сумын Засаг дарга (Б.Дэлгэр), Дашинчилэн сумын Засаг дарга (Д.Луттөмөр) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тус компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), Татварын газрын дарга (Д.Лхагвасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3захирамж

6324010980

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 17-ны/ний өдрийн А/695 дугаар
захирамжийн хавсралт

# БУЛГАН-ОРХОН-ХИШИГ-ӨНДӨР-ГУРВАНБУЛАГ СУМ ЧИГЛЭЛИЙН 133.7 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛД ШААРДАГДАХ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙХ, АШИГЛАХ СОЛБИЦОЛ

| д/д | Нэр | Ашигт малтмалын тоо хэмжээ ($м^3$) | Координат | | |
|---|---|---|---|---|---|
| | | | № | Уртраг | Өргөрөг |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Карьер 1 | 90 000 | 1 | 103° 25' 18.72" | 47° 51' 1.65" |
| | | | 2 | 103° 25' 16.61" | 47° 51' 6.12" |
| | | | 3 | 103° 25' 33.30" | 47° 51' 5.89" |
| | | | 4 | 103° 25' 33.77" | 47° 51' 1.03" |
| 2 | Карьер 2 | 60 000 | 1 | 103° 22' 54.94' | 47° 52' 44.38" |
| | | | 2 | 103° 22' 58.9" | 47° 52' 44.78" |
| | | | 3 | 103° 22' 49.05" | 47° 53' 3.25" |
| | | | 4 | 103° 22' 52.95" | 47° 53' 3.74" |
| 3 | Карьер 3 | 60 000 | 1 | 103° 22' 52.95" | 47° 53' 3.74" |
| | | | 2 | 103° 22' 54.18" | 47° 52' 59.82" |
| | | | 3 | 103° 23' 14.64" | 47° 53' 3.30" |
| | | | 4 | 103° 23' 14.32" | 47° 53' 0.37" |
| 4 | Карьер 4 | 70 000 | 1 | 103° 22' 58.90" | 47° 52' 44.78" |
| | | | 2 | 103° 23' 4.96" | 47° 52' 45.27" |
| | | | 3 | 103° 23' 3.37" | 47° 52' 51.38" |
| | | | 4 | 103° 22' 59.73" | 47° 52' 53.08" |
| | | | 5 | 103° 22' 54.18" | 47° 52' 59.82" |
| | | | 6 | 103° 22' 59.10" | 47° 52' 59.96" |
| 5 | Карьер 5 | 1 000 | 1 | 104° 3' 49.30" | 47° 49' 41.79" |
| | | | 2 | 104° 3' 46.96" | 47° 49' 39.33" |
| | | | 3 | 104° 3' 41.08" | 47° 49' 39.61" |
| | | | 4 | 104° 3' 44.38" | 47° 49' 37.88" |